

Батлав:
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Хошууч генерал Т.Бадрал

**“ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНД ХУВЦАС ХЭРЭГЛЭЛ ХУДАЛДАН АВАХ”
ОБЕГ/201901002-2 ТООТ ТЕНДЕРИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Багц 3. Ёслол албаны китель, өмд

Зориулалт	Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын эрэгтэй албан хаагч ёслол болон өдөр тутамд өмсөж хэрэглэнэ.
Шинж чанар	Хувцасны үндсэн материал Pantone систем дэх өнгөний 19-4027 TPX код бүхий хөх (Estate Blue) өнгөтэй, 60%-аас багагүй ноосны холиотой материалтай байна.
	<p>Их бие – Захны ирмэгт 0.2 см-ийн өргөнтэй, – Pantone систем дэх өнгөний 17-1464 TPX код бүхий улбар шар (Red Orange) өнгөтэй ноосон одончуугаар хавчуурга хийсэн байна. Мөрдэс тогтоогч 4.5 см өргөн, 10.5 см урттай байх ба мөрний оёдлоос ар тийш 0.5смдавуулж ханцуй залгасан оёдолд оруулж, задгай үзүүрийг жижиг товчоор товчилж тогтооно. Баруун талын мөрдэс тогтоогчийн дор ханцуй залгаасны оёдлоос 1см-ийн зайд акселбантны эвэр товч хадаж өгнө. Энгэрийн дээд, доод хэсэгт суулгаж оёсон тагтай, товчтой, хоорондоо 5 см-ийн зайтай 0.2см-ийн чимэг оёдолтой ил халаастай. Энгэрт байгууллагын эмблем бүхий 4ш товчтой байх ба энгэрийн дээд товчны байрлал нь энгэрийн дээд халаасны товчтой ижил түвшинд байх ба товчны хоорондын зай 8.0-8.5 см байна. Кителийн товчны нүхийг энгэрийн ирмэгээс 1.8 см зайнд 2.5 см урттай байна. Арынголдоноотой.</p> <p>Ханцуй- Баруун ханцуйнд соёмбо бүхий тэмдэг, зүүн ханцуйнд байгууллагын билгэдэлийг ханцуйн оройн цэгээс доош 12 см-т хадна. Том ханцуйнд нударганы оруулгатай, оруулганд 0.2 см-ийн хавчуурга хавчуулж оёно. Ханцуйн оноонд 3 ш жижиг товчийг суулгаж өгсөн байна.</p> <p>Оёдлынхэмжээсүүд – Зах, бартаа, энгэрийн урд болон хормойгоор, халаас, халаасны таг, мөрдэс тогтоогчийг 0.6см-ийн ил оёдлоор оёно. Энгэр, бусад бүрдэл хэсгүүдийн хатуулга, наалт материалын шинж чанарт бүрэн тохирсон, чийг дулааны болон оёх технологийн горим алдагдаагүй байх шаардлагатай.</p> <p>Хувцас бүр бүтээгдэхүүний онцлогт тохирсон цэвэрлэгээний шошготой байна.</p>
	<p>Өмдний ташаанд улбар шар өнгийн ноосон одончуу материалаар 0.2см-ийн өргөнтэй хавчуургатай байна.</p> <p>Бүс, халаа - Өмдний дотор бүс зориулалтын захны корсажтай байна. Өмдний арын суудлын оёдлоос хоёр тийш 4.0 см зайнд, баруун, зүүн хажуугийн оёдлоос 1.0 см хойно, урд талын нугалаасны харалдаа тус тус бүгд 6 ширхэг түдүүл оёно. Халаа нарийн сайн чанарын цахилгаантай байна. Давхар халаа гурвалжин хэлбэртэй товчны нүх гаргасан байна. Бүсний дотор талд товч хадаж, давхар халаа товчлогдож, бүсний гадна талд зориулалтын сайн чанарын төмөр дэгээг хийнэ.</p> <p>Өмдний урд гуяны дотор талд өвдөгний шугамнаас доош урттай дотрын материалыг барьж оёсон байна.</p> <p>Халаас - Хажуугийн ташуу халаастай, ар талд 2ш 2 хажлагатай, товчтой хагалбар халаастай, баруун талын халаас тагтай, таган доор товчны гогцоотой. Халаас болон халаанд 1.6см-ийн диаметртэй өнгө дагуу эвэр товч байна.</p>

	<p>Шуумгаг- Шуумагны тасамтай байна.</p> <p>Бөхөлгөө - Хажуугийн ташуу халаас, арын халаас, түдүүлийг тусгай зориулалтын машинаар бөхөлсөн байна.</p> <p>Захиалагчаас үндсэн материалыг нийлүүлнэ.</p> <p>Загварыг 50.3-аар ирүүлнэ.</p>
Баглаа боодол	Нэг бүрчлэн мөр өлгүүрт өлгөж, зориулалтын уутанд савлаж, хэмжээ чацыг бичсэн үйлдвэрлэгчийн шошгийг хадсан байна.
Тоо ширхэг	700 хос
Гэрээнд тусгагдах тусгай нөхцөл	<ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрлэл эхлэхийн өмнө үндсэн ба туслах материал, үлгэр загварыг захиалагч талын мэргэжилтэнд үзүүлж зөвшөөрөл авна. 2. Захиалагч талаас үйлдвэрлэх технологи ажиллагааны явцад давхар хяналт тавина. 3. Залруулж болохуйц технологийн алдааг захиалагч талын шаардлагаар засна.

Багц 3. Ёслол албаны китель, юбка

Зориулалт	Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчид ёслолын арга хэмжээнд өмсөх зориулалттай.
Шинж чанар	Хувцасны үндсэн материал Pantone системдэхөнгөний 19-4027 TPX кодбүхий хөх (Estate Blue) өнгөтэй, 60%-аас багагүй ноосны холиотой материалтай байна. Хүний биед суулт тохироо сайтай, эргономик үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай
	<p>Их бие – Энгэр босоо оруулгатай, захны ирмэгт 0.2 см-ийн өргөнтэй, – Pantone систем дэх өнгөний 17-1464 TPX код бүхий улбар шар (Red Orange) өнгийн ноосон одончуугаар хавчуурга хийсэн байна. Мөрдэс тогтоогч 4.5см өргөн, 10.5см урттай байх ба мөрний оёдлоос ар тийш 0.5см давуулж ханцуй залгасан оёдолд оруулж, задгай үзүүрийг жижиг товчоор товчилж тогтооно. Баруун талын мөрдэс тогтоогчийн дор ханцуй залгаасны оёдлоос 1см-ийн зайд акселбантны эвэр товч хадаж өгнө. Энгэрийн дээд талд товчтой тагтай, доод хэсэгт суулгаж оёсон тагтай, товчтой, хоорондоо 5 см-ийн зайтай 0.2см-ийн чимэг оёдолтой ил халаастай. Энгэрт байгууллагын эмблем бүхий 4ш товчтой байх ба энгэрийн дээд товчны байрлал нь энгэрийн дээд халаасны товчтой ижил түвшинд байх ба товчны хоорондын зай 8.0-8.5 см байна. Кителийн товчны нүхийг энгэрийн ирмэгээс 1.8 см зайнд 2.5 см урттай байна.</p> <p>Ханцуй- Баруун ханцуйнд соёмбо бүхий тэмдэг, зүүн ханцуйнд байгууллагын билгэдлийг ханцуйн оройн цэгээс доош 12 см-т хадна. Том ханцуйнд нударганы оруулгатай, оруулганд 0.2 см-ийн хавчуурга хавчуулж оёно. Ханцуйн оноонд 3ш жижиг товчийг суулгаж өгсөн байна.</p> <p>Оёдлын хэмжээсүүд-Зах, бартаа, энгэрийн урд болон хормойгоор, халаас, халаасны таг, мөрдэс тогтоогчийг 0.6см-ийн ил оёдлоор оёно. Энгэр, бусад бүрдэл хэсгүүдийн хатуулга, наалт материалын шинж чанарт бүрэн тохирсон, чийг дулааны болон оёх технологийн горим алдагдаагүй байх шаардлагатай.</p> <p>Хувцас бүр бүтээгдэхүүний онцлогт тохирсон цэвэрлэгээний шошготой байна.</p> <p>Захиалагчаас үндсэн материалыг нийлүүлнэ.</p>


		<p>Юбканы ташааны оёдолд 0.2см-ийн өргөнтэй, улбар шар өнгийн ноосон одончуухавчуургатай, арын голд оноотой, далд цахилгаантай, 1.6см-ийн диаметртэй эвэр товчоор товчлогдоно. Юбка нь ардаа 4, урдаа 2ш танаастай, бүсэнд 1 см өргөнтэй, 4,5 см урттайтүдүүлтэй байна. Өмд, юбканы түдүүл, өмдний хажуу халаасанд тусгай зориулалтын бөхөлгөө хийнэ.</p>
<p>Загварыг 46.3 размераар ирүүлнэ.</p>		
<p>Баглаа боодол</p>	<p>Нэг бүрчлэн мөр өлгүүрт өлгөж, зориулалтын уутанд савлаж, хэмжээ чацыг бичсэн үйлдвэрлэгчийн шошгийг хадсан байна.</p>	
<p>Тоо ширхэг</p>	<p>300 хос</p>	
<p>Гэрээнд тусгагдах тусгай нөхцөл</p>	<ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрлэл эхлэхийн өмнө үндсэн ба туслах материал, үлгэр загварыг захиалагч талын мэргэжилтэнд үзүүлж зөвшөөрөл авна. 2. Захиалагч талаас үйлдвэрлэх технологи ажиллагааны явцад давхар хяналт тавина. 3. Залруулж болохуйц технологийн алдааг захиалагч талын шаардлагаар засна. 	

Багц 3. Хээрийн зуны хүрэм, өмд, малгай, мөрдөс

<p>Зориулалт</p>	<p>Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчид зуны улиралд өмсөх зориулалттай.</p>
<p>Шинж чанар</p>	<p>Ногоон саарал дижитал өнгөлөн далдлалтын хээ бүхий /Өнгөний бүрэлдэхүүн нь хар ногоон- өнгөний Pantone систем дэх 19-0307 TPX код бүхий Climbing Ivy, саарал- 18-4105 TPX код бүхий Moon mist, цайвар шаргал 15-1307 TPX код бүхий White pepper өнгөтэй байна/ хүрэм өмдний хослол байна. Үндсэн материалын бүтэц холио нь 60 хувиас багагүй хөвөн, 20 хувиас багагүй полистер, 20 хүртлэх хувийн нейлонтой байна. Нэхээсний нягт туушид 440-с, хөндлөнд 220-с багагүй, зузаан 0.41±0,01 мм, даац туушид 90кг, хөндлөнд 63 кг хүчнээс багагүй, суналт туушид 22%, хөндлөнд 15%-аас багагүй, агшилт туушид 0.5%-аас ихгүй, будгийн тогтвор хуурайд 4-5 балл, нойтонд 4-5 балл үзүүлэлттэй байна. Материал нь тэгш нэхээстэй, 0.5 см-ийн шоо дөрвөлжин үндсэн өнгө дагуу хээтэй байна. Материалын бүтэц холио болон шинж чанарын үзүүлэлтийг Ноос ноолуурын сорилтын төвийн лабораторийн дүгнэлтээр баталгаажуулсан байна.</p>
<p>Эрүүл ахуйн шаардлага</p>	<p>Будаг гардаггүй, хүний биед харшил өгөх гаж нөлөөгүй, агаар нэвтрүүлдэг, эргономик үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай.</p>

	<p>Их бие – Өмдний гадуур тавьж өмсөх зориулалттай. Эргэсэн зах бартаатай, энгэр болон ташаанд 2ш 3 см-ийн өргөн эзэлхүүнтэй, тагтай ил халаастай, халааснуудын таг хуванцар товчоор далд товчлогдоно. 4см-ийн өргөн, 12см-ийн урттай мөрдэс тогтоогчтой. Энгэр далд товчлоостой ба 5ш хуванцар товчоор товчлогдоно. Энгэрийн халааснуудын дээд талд 13 см-ийн урттай зөөлөн зангууг тойруулан оёж, зүүн халаасны ширүүн зангууг нэрний хатгамал тогтоох зориулалтаар нааж оёсон байна. Ар үргэлж эсгэгдсэн далны хөндийрүүлэгчтэй байна.</p> <p>Ханцуй- Тохойн оёдолд чөлөөт хөдөлгөөнийг хангасан 1см-ийн гүн 2ш нугалаас орсон байна. Ханцуйнд ташуу байрлуулсан тагтай, ил халаастай. Зүүн ханцуйнд өнгө дагуу байгууллагын билгэдэл, баруун ханцуйнд соёмбо бүхий тэмдгийг хадна. Ханцуйн үзүүр сойлттой хуванцар товчоор товчилно. Хүрэмний зах, ханцуйн манжет, халаасны таг, далд товчлоосонд сайн чанарын цаасан наалт наасан байна. Хуванцар товчнууд бүгд 1.6 см-ийн диаметртай байна.</p> <p>Хувцас бүр бүтээгдэхүүний онцлогт тохирсон цэвэрлэгээний шошготой байна</p>
	<p>Бүс – Өмдний зах нь үргэлж эсгэгдсэн, хошуу хэлбэрийн өргөн давхар 5ш түдүүлтэй.</p> <p>Халаас, халаа – Тус бүр 2ш хажуугийн ташуу халаас, ташаанд эзэлхүүнтэй, тагтай ил халаас, ард 1 хажлагатай тагтай хагалбар халаастай. Халаасны таг далд товчтой байна. Халаан нарийн төмөр шүдтэй сайн чанарын цахилгаантай байна. Урд талд өвдөгний хэлбэр гаргасан хуниастай, өвдөг давхарлагатай. Өвдөгний ар талд тахимны хэсэгт 2 см-ээр резинээр татаж оёсон байна.</p> <p>Шуумаг- Өмдний шуумаг гутланд чихэж өмсөх зориулалтаар бүчтэй байна</p> <p>Оёдлын хэмжээсүүд - Цамцны зах, тохойн оёдол, мөр, ханцуйн оёдол, халаасны таг суулгах, өмдний ташаан оёдлууд 0.5 см, ар, урд суудал, өвдөг, суудлын давхарлага 0.1-0.6, халаасны уут, таг, ханцуйн манжет, түдүүл, халаан урд ирмэг, өмдний захны эргэн тойрон 0.1 см-ийн ил оёдлоор оёгдоно.</p> <p>Бөхөлгөө- Цамцны далд товчлоосны дээд ирмэг, халаасны таг, уутны амсар, ханцуйн хагалбарын төгсгөл, сойлт тогтоогч, өмдний халаа, халаасны тагны ирмэг, уутны амсар хэсгүүдэд тусгай зориулалтын машинаар бөхөлгөө хийнэ. Хар ногоон өнгийн эдэлгээнд тэсвэртэй, сэтэрдэггүй, товчоор товчлогдоно.</p>
<p>Загварыг эрэгтэй 50.3 размераар ирүүлнэ.</p>	
<p>Тоо ширхэг</p>	<p>1500 хос</p>
<p>Баглаа боодол</p>	<p>Нэг бүрчлэн зориулалтын уутанд савлаж, хэмжээ чацыг бичсэн үйлдвэрлэгчийн шошгийг хадсан байна.</p>
<p>Гэрээнд тусгагдах тусгай нөхцөл</p>	<ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрлэл эхлэхийн өмнө үндсэн ба туслах материал, үлгэр загварыг захиалагч талын мэргэжилтэнд үзүүлж зөвшөөрөл авна. 2. Захиалагч талаас үйлдвэрлэх технологи ажиллагааны явцад давхар хяналт тавина. 3. Залруулж болохуйц технологийн алдааг захиалагч талын шаардлагаар засна.

Багц 3. Хээрийн малгай

Зориулалт	Онцгой байдлын байгууллагын албан хаагчид зуны улиралд хээрийн хүрэм, өмдтэй өмсөх зориулалттай саравчтай малгай.
Шинж чанар	Ногоон саарал дижитал өнгөлөн далдлалтын хээ бүхий /Өнгөний бүрэлдэхүүн нь хар ногоон- өнгөний <i>Pantone систем дэх 19-0307 TPX</i> код бүхий Climbing Ivy , саарал- 18-4105 TPX код бүхий Moon mist , цайвар шаргал 15-1307 TPX код бүхий White pepper өнгөтэй байна/ саравчтай малгай байна. Үндсэн материалын бүтэц холио нь 60 хувиас багагүй хөвөн, 20 хувиас багагүй полистер, 20 хүртлэх хувийн нейлонтой байна. Нэхээсний нягт туушид 440-с, хөндлөнд 220-с багагүй, зузаан 0.41±0,01 мм, даац туушид 90кг, хөндлөнд 63 кг хүчнээс багагүй, суналт туушид 22%, хөндлөнд 15%-аас багагүй, агшилт туушид 0.5%-аас ихгүй, будгийн тогтвор хуурайд 4-5 балл, нойтонд 4-5 балл үзүүлэлттэй байна. Материал нь тэгш нэхээстэй, 0.5 см-ийн шоо дөрвөлжин үндсэн өнгө дагуу хээтэй байна. Материалын бүтэц холио болон шинж чанарын үзүүлэлтийг Ноос ноолуурын сорилтын төвийн лабораторийн дүгнэлтээр баталгаажуулсан байна.
Эрүүл ахуйн шаардлага	Будаг гардаггүй, хүний биед элдэв харшил өгөх нөлөөгүй байна.
	
<p>Малгайны орой зуйван хэлбэртэй, хүрээнд эргэсэн чихтэй байна. Цохонд хатгамал шар өнгөтэй хатгамал соёмботой, саравчны ирмэгийг 0.5 см-ийн өргөн эмжиж оёно. Саравчны өнгө, дотрыг сайн чанарын даавуун наалтаар наасан байна. Малгайн цохийг голлож зөв тэгш оёсон байна.</p> <p>Дотор: Үндсэн өнгийн даавуугаар хийнэ.</p>	
Тендерийн материалын хамт загвар ирүүлнэ.	
Тоо ширхэг	1500ш
Баглаа боодол	Нэг бүрчлэн хэмжээ бичсэн үйлдвэрлэгчийн шошгийг хадаж, хэлбэрийг алдагдуулж дарагдуулахгүйгээр уутанд савлаж, багцлан цаасан хайрцганд хийсэн байна.

Багц 3. Хээрийн мөрдэс

Зориулалт	Албан хаагчид өвөл, зуны хээрийн хувцсанд зүүж хэрэглэнэ.
------------------	---

	<p>Шинж чанар – 5.0см х 9.5см хэмжээтэй, дижитал өнгөлөн далдлалтын хээ бүхий /Өнгөний бүрэлдэхүүн нь хар ногоон- өнгөний Pantone систем дэх 19-0307 TPX код бүхий Climbing Ivy, саарал- 18-4105 TPX код бүхий Moon mist, цайвар шаргал 15-1307 TPX код бүхий White pepper өнгөтэй байна/ материалтай байна. Үндсэн материалын ард нь цаасан наалт наан хатуулж, дээр нь хар өнгийн торгон утсаар цол зэрэглэлийг хатгаж хийсэн байна. Мөрдэсний дээд доод ирмэгт материалын өнгө дагуу утсаар нарийн хязгаарлалт хийж өгсөн байна.</p> <p>Эрүүл ахуйн шаардлага – Будаг гардаггүй, хүний биед харшил өгөх нөлөөгүй байна.</p>
Тендерийн материалын хамт загвар ирүүлнэ.	
Баглаа боодол	100 ширхэгээр уутлаж савласан байна.
Тоо ширхэг	1500 хос

Багц 7. Хээрийн өвлийн хүрэм, өмд, /цегейк захтай, нэхий дотортой/

Зориулалт	Цэргийн албан хаагчид өвлийн улиралд өмсөх зориулалттай.
Шинж чанар	<p>Ногоон саарал дижитал өнгөлөн далдлалтын хээ бүхий /Өнгөний бүрэлдэхүүн нь хар ногоон- өнгөний Pantone систем дэх 19-0307 TPX код бүхий Climbing Ivy, саарал- 18-4105 TPX код бүхий Moon mist, цайвар шаргал 15-1307 TPX код бүхий White pepper өнгөтэй байна/ үндсэн материалтай, салдаг хар хөх өнгийн цегейк /натураль/ үсэн захтай, нэхий /натураль/ дулаалгатай хүрэм болон салдаг дулаалгатай өмдний хослол байна. Үндсэн материалын бүтэц холио нь 60 хувиас багагүй хөвөн, 20 хувиас багагүй полистер, 20 хүртлэх хувийн нейлонтой байна. Нэхээсний нягт туушид 440-с, хөндлөнд 220-с багагүй, зузаан 0.41±0,01 мм, даац туушид 90кг, хөндлөнд 63 кг хүчнээс багагүй, суналт туушид 22%, хөндлөнд 15%-аас багагүй, агшилт туушид 0.5%-аас ихгүй, будгийн тогтвор хуурайд 4-5 балл, нойтонд 4-5 балл үзүүлэлттэй байна. Материал нь тэгш нэхээстэй, 0.5 см-ийн шоо дөрвөлжин үндсэн өнгө дагуу хээтэй байна.</p> <p>Материалын бүтэц холио болон шинж чанарын үзүүлэлтийг Ноос ноолуурын сорилтын төвийн лабораторийн дүгнэлтээр баталгаажуулсан байна.</p>
Эрүүл ахуйн шаардлага	Хүний биеийг гадны нөлөөллөөс хамгаалж, дулаан хадгалах чадвар сайтай, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, эргономик үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай.
Гадаад байдлын зураг	



Үйлдвэрлэх технологи

Их бие - Хөдөлгөөнд саад учруулахгүй сул чөлөөтэй, өгзөг давсан урттай. Энгэрт тагтай, эзэлхүүнтэй ил халаастай, тагтай цахилгаантай хагалбар халаастай. Энгэрийн цахилгаан товчлоос нь энгэртэй үргэлж эсгэгдсэн хаалттай. Ар далны хөндийрүүлэгчтэй, дотор талаас нь өргөн резинээр татсан байна. Их биенд гуурсаар дотор тал руу гарсан чангалуур шнуран бүстэй, зориулалтын хязгаарлагч, толгойтой. Кнопка болон гуурсийг зориулалтын машинаар мултрахгүй, бат бөх хадсан байна.

Юүдэн- голдоо сойлттой, ширмэл саравчтай, цахилгаан товчоор салдаг, 2ш кнопкагаар товчилж, урд ирмэгээр шнур далд гүйлгэн, үзүүрийг гуурсаар гарган, зориулалтын хязгаарлагч, толгой хийнэ.

Ханцуй –Тохойн оёдолтой, давхарлагатай, зүүн ханцуйн дээр тагтай хагалбар халаастай байна. Ханцуйн үзүүрт хошуу хэлбэрийн сойлттой 1.8 см-ийн диаметртэй 2ш хуванцар товчоор товчлоно. Ханцуйнд хувцасны өнгө дагуу ханцуйн тэмдэг, билэгдэлтэй байна.

Салдаг дулаалга– Цегейк захтай нэхий дулаалга нь цулгай цагаан өнгөтэй, зүйдэлгүй, үсний өндөр 1.5 см-ээс багагүй, жигд тайралттай, хөрсний хугаралтгүй, гэмтэлгүй, үйлдвэрийн нөхцөлд технологийн горимын дагуу боловсруулсан арьс байна. Хүрэмний бүрдэл хэсгийг эсгэхдээ үсний чигийг анхааран эсгэж, тусгай зориулалтын машинаар хөвөрдөж нэгтгэсэн байна. Захны ухлаадас, энгэр, хормой, ханцуйн үзүүр зэргийг зориулалтын 0.7см-н өргөнтэй туузан материалаар суналтнаас хамгаалан эмжинэ. Нэхий дулаалганы ханцуйн үзүүрт 8см-ийн өргөнтэй нарийн давхар нэхээстэй, резинтэй сүлжмэл манжеттай байна. Нэхий дулаалгыг их биенд энгэр талдаа 5ш /нийт10ш/, арын голд 1ш, ханцуйн үзүүрт тус бүр 2ш товчоор товчлон тогтооно. Нэхий дулаалганд контур товч хадаж өгнө.



Салдаг ширмэл дулаалгатай өмд байна. Өргөн бүстэй, 6ш түдүүлтэй. Оёдолд орсон хажуугийн ташуу халаастай, ташаанд эзэлхүүнтэй, тагтай ил халаастай. Халаа нарийн цахилгаантай байна. Урд талд өвдөгний хэлбэр гаргасан хуниастай, өвдөг болон ар суудал давхарлагатай

Оёдлын хэмжээсүүд- Хүрэмний энгэрийн планк, халаасны уут, таг, зах, тохойн оёдол, мөр, ханцуйн оёдол, далны хөндийрүүлэгч, ташаан оёдолууд 0.5 см, ар, урд суудал, өвдөг, суудлын давхарлага 0.1-0.6, түдүүл, халаан урд ирмэг 0.1 см-ийн ил оёдлоор оёгдоно.

Тусгай зориулалтын бөхөлгөө - Халааны төгсгөлд 2ш, түдүүл, халаасны таг болон амсарт, планканы эхлэл төгсгөлд тусгай зориулалтын, цэвэр үзэмжтэй бөхөлгөөтэй байна. Хүрэмний энгэрийн халааснуудын тагны урд талын доод үзүүрүүдийг бөхөлнө. Хувцас бүр бүтээгдэхүүний онцлогт тохирсон цэвэрлэгээний шошготой байна.	
Дээж загварыг эрэгтэй 50/3, эмэгтэй 48/3-д тохирох хэмжээтэйгээр ирүүлнэ.	
Баглаа боодол	Нэг бүрчлэн зориулалтын уутанд савлаж, хэмжээ болон үйлдвэрлэгчийн шошгийг хадсан байна.
Тоо ширхэг	1000 хос
Гэрээнд тусгагдах тусгай нөхцөл	1. Үйлдвэрлэл эхлэхийн өмнө үндсэн ба туслах материал, үлгэр загварыг захиалагч талын мэргэжилтэнд үзүүлж зөвшөөрөл авна. 2. Захиалагч талаас үйлдвэрлэх технологи ажиллагааны явцад давхар хяналт тавина. 3. Залруулж болохуйц технологийн алдааг захиалагч талын шаардлагаар засна.

Багц 11 Гал сөнөөгчийн хүн нэг бүрийн хувцас хэрэглэл /барилга байгууламжийн/ 500ком

Байлдааны сүх, сүхний гэр 500 ш /тус бүр/

Бага оврын сүх нь нэг талдаа ир нөгөө талдаа зээтүү хэлбэртэй, 1000 вольт хүртэл цахилгаан гүйдлээс хамгаалагдсан тусгаарлагч бүхий бариултай, зээтүү хэлбэртэй тал нь 100 кг хүртэл ачаалал даах чадвартай сайн чанарын гангаар хийгдсэн, зориулалтын гэртэй байна. Тендерийн материалын хамт загвар ирүүлнэ.

Жин	1кг-аас ихгүй,
Оврын хэмжээ:	
Урт	34 см
Өргөн	20 см
Зузаан	2 см

Ослын бэхэлгээ /карбин/ 500 ш

Таталт тэсвэрлэх чадал,к/н	50-с багагүй
Цоожлогч	Автомат
Түгжээний урт, мм	23.8
Уртын хэмжээ, мм	114.8
Өргөний хэмжээ, мм	70
Ачаа даах байдал хөндлөн чигтээ	2200кгс
Түгжээ нь онгорхой үед	700кгс
Зэвэрдэггүй гангаар хийгдсэн байна.	
Жин, гр	180
Тендерийн материалын хамт загвар ирүүлнэ.	

Гал сөнөөгчийн барилга байгууламжийн гал түймрээс хамгаалах өмсгөл

Зориулалт	Хязгаарлагдмал талбай бүхий газар, байгууламжийг хамарсан гал түймрийг унтраах болон түүнээс аврах ажиллагааг гүйцэтгэхэд орчны аюултай, хөнөөлт хүчин зүйлсээс гал сөнөөгчийг хамгаалах шар өнгийн тусгай зориулалтын хүрэм өмд байна.	
Чанар стандарт	<p>Хүрэм нь галын бүс тогтоох түдүүлтэй, хүйтний улиралд өмсөх зориулалт бүхий салдаг дулаалгатай, дулаалганы гадар ус чийг нэвтрүүлдэггүй байна. Хүрэм гал, цог унахад хамгаалах салдаг дэл /мөр, далны давхарлага/-тэй байна. Хүрэмний арын цээжин хэсэгт “ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБА” гэсэн бичигтэй гэрэл ойлгогч түрхлэгтэй туузыг дарж оёсон байна. Уг бичиг нь гэрэлгүй үед ч уншигдах боломжтой байна. Эргономикийн үзүүлэлтийг бүрэн хангасан, гал сөнөөгчдийн гар доорхи багаж хэрэгслэлийг хийх халаас, тоноглолтой байна. Өмдний шуумагыг хумих зангуу бүхий сойлттой байна. Өмсгөлийн стандарт онцлогтой тул олон улсын өмсгөлийн стандартад шилжүүлсэн хүснэгтийг ирүүлнэ.</p> <p>Гал сөнөөгчийн байгууламжийн гал түймрээс хамгаалах хувцас /БХ/-ны чанарт тавих шаардлага нь MNS 6348:2012 стандартад заасантай дүйцэх эсхүл түүнээс илүү чанартай, олон улсын стандартад нийцсэн бол хүлээн зөвшөөрнө.</p> <p>Гал сөнөөгчийн хувцасны гадар материалын бүтцийн гал тэсвэрлэх чанарыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн лабораторын дүгнэлт эсхүл “ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгийн” шинжилгээний дүгнэлтээр баталгаажуулсан байна.</p> <p>Хувцас бүр бүтээгдэхүүний онцлогт тохирсон цэвэрлэгээний шошготой байна.</p>	
Тоо ширхэг	500 хос	
Баглаа боодол	Уутанд савлаж, хэмжээ чацыг бичсэн үйлдвэрлэгчийн шошго хадсан байна.	
Тендерийн материалын хамт 52/4 хэмжээтэй загвар ирүүлнэ		

Гал сөнөөгчийн хамгаалах дуулга малгай

Зориулалт	Гал түймэр унтраах, аврах ажиллагаа явуулах үед хөнөөлт хүчин зүйлсийн механик болон температурын үйлчлэл, химийн бодис, ус, цаг агаарын тааламжгүй байдлаас хүний толгой, хүзүү, нүүрийг хамгаалахад зориулагдсан цагаан өнгийн дуулга малгай байна.	
Чанар стандарт	<p>Хамгаалах дуулга нь гадны нөлөөллийг саармагжуулах хамгаалалтын чанартай, доторлогоо нь зориулалтын хөндийрүүлэгчтэй, дух, ар шилэнд зөөлөвчтэй. Нүүрний хамгаалалт нь галд тэсвэртэй /буугч/ целлиодон хамгаалагчтай. Дуулганы хүзүүний хамгаалалт урт байх, хойд талдаа зориулалтын нөмрөгтэй байна. Дуулга нь дотуур өмсөх зориулалттай, гал тэсвэрлэх чадвар бүхий давхар сүлжмэл ноосон болон ноосны зохих хэмжээний хольц бүхий сүлжмэл даавуун юүдэн малгайтай байна.</p> <p>Гал сөнөөгчийн дуулга малгайд тавих шаардлага нь MNS 6349:2012 стандартад заасантай дүйцэх эсхүл түүнээс илүү чанартай, олон улсын стандартад нийцсэн бол хүлээн зөвшөөрнө.</p> <p>Импортын бүтээгдэхүүнд нормативт нийцсэн тухай болон хамгаалах шинж чанаруудыг туршиж баталгаажуулсан тухай сертификат дагалдуулсан байна.</p>	
Тоо ширхэг	500 ширхэг	
Баглаа боодол	Размер, рост болон бэлтгэн нийлүүлэгчийн нэрийг бичсэн байна.	
Тендерийн материалын хамт загвар ирүүлнэ.		

Гал сөнөөгчийн хамгаалалтын аврах бүс

Зориулалт	Гал сөнөөгчийг гал түймрийг унтраах болон түүнээс аврах ажиллагааг гүйцэтгэх үед өндөрт ажиллах, хүмүүсийг болон өөрийгээ аврахад аюулгүй байдлыг хангах, түүнчлэн сүх, карабин зэрэг хэрэгслийг зүүж явахад зориулагдсан хувийн хамгаалах хэрэгсэл-бүс байна.
Чанар стандарт	Бүсний өргөн нь 80 мм, жин нь 0.65-0.75 кг байна. Бүс нь карабины бэхэлгээ, багаж хэрэгсэл зүүх зориулалттай гогцоо, хос хэлтэй арал, гархинаас бүрдэнэ. Карабины бэхэлгээ, арал, гархи нь хат сайтай металл байх шаардлагатай ба 350 кг ачааг тодорхой хугацаанд /8 мин-аас багагүй/ даах чадвартай байна. Галд тэсвэртэй, 4 давхар нэхээстэй /зузаан 4 мм/ материалаар хийгдсэн байна. Гал сөнөөгчийн бүсэнд тавих шаардлага нь <i>MNS 6349:2012</i> стандартад заасантай дүйцэх эсхүл түүнээс илүү чанартай, олон улсын стандартад нийцсэн бол хүлээн зөвшөөрнө. Импортын бүтээгдэхүүнд нормативт нийцсэн тухай болон хамгаалах шинж чанаруудыг туршиж баталгаажуулсан тухай сертификат дагалдуулсан байна.
Тоо ширхэг	500 ш
Баглаа боодол	Уутанд савлаж үйлдвэрлэгчийн шошго хадсан байна.
Тендерийн материалын хамт загвар ирүүлнэ.	

Гал сөнөөгчийн бээлий

Зориулалт	Гал сөнөөгчийн гарыг гал түймэр унтраах, аврах ажиллагаа явуулах үед орчны хөнөөлт хүчин зүйлсээс (өндөр температур, халуун гадаргуутай хүрэлцэх, механик үйлчлэл: хатгалт, зүсэлт г.м, ус, гадаргуугийн идэвхт бодисын үйлчлэл), мөн цаг агаарын тааламжгүй үйлчлэлээс (хүйтэн, хур тунадас, салхи) хамгаалах зориулалттай, байлдааны хувцастай иж бүрдлээр ашиглагддаг хамгаалах тусгай зориулалтын бээлий байна.
Чанар стандарт	Гадар материал галд тэсвэртэй, ус нэвтэрдэггүй, хуруунууд илгэн, дотор нь арьсан байх шаардлагатай. Гарын хөдөлгөөн хорихооргүй байна. Бээлийний урт бугуйнаас 13см-аас багагүй урттай, бугуйнд чангалах зориулалттай зангуу бүхий сойлттой байна. Гал сөнөөгчийн бээлийнд тавих шаардлага нь <i>MNS 6349:2012</i> стандартад заасантай дүйцэх эсхүл түүнээс илүү чанартай, олон улсын стандартад нийцсэн бол хүлээн зөвшөөрнө. Импортын бүтээгдэхүүнд нормативт нийцсэн тухай болон хамгаалах шинж чанаруудыг туршиж баталгаажуулсан тухай сертификат дагалдуулсан байна.
Тоо ширхэг	500 хос
Баглаа боодол	Хос хосоор нь бэхэлж, багцлан зориулалтын хайрцганд хийсэн байна.
Тендерийн материалын хамт загвар ирүүлнэ	

Гал сөнөөгчийн тусгай зориулалтын гутал /БХ/

Зориулалт	Гал сөнөөгчийг гал түймэр унтраах, аврах ажиллагаа явуулах боломжийг хангасан, мөн цаг агаарын тааламжгүй үйлчлэлээс хамгаалах, эрүүл ахуй, эргономикийн болон хамгаалалтын цогц үзүүлэлтүүд бүхий тусгай зориулалтын хамгаалах гутал байна.
Чанар стандарт	<p>Гал сөнөөгчийн гутал нь гал түймэртэй тэмцэх, аврах сэргээн босгох үед өмсөх олон улсын стандартад нийцсэн тусгай зориулалтын, галд хайлж шатахгүй, ус нэвчихгүй, 1000N ачааны хүндийн даацтай, 5000V-с багагүй цахилгаан хүчдэлээс хамгаалж байх шаардлагатай байна. Гутлын хоншоор нь төмөр хатуулгатай байна. Физиологи-эрүүл ахуйн шинж чанараараа үслэг арьснаас дутуугүй материалаар хийгдсэн угладаг үслэг оймстой байна.</p> <p>Хүний хөдөлгөөнд саадгүй, өмсөхөд хялбар, биед гаж нөлөөгүй, доторлогоо нь дулаан, ус чийг татахгүй байна. Гутлын зуузай хатуу байна.</p> <p>Гал сөнөөгчийн гутланд тавих шаардлага нь MNS 6349:2012 стандартад заасантай дүйцэх эсхүл түүнээс илүү чанартай, олон улсын стандартад нийцсэн бол хүлээн зөвшөөрнө.</p> <p>Импортын бүтээгдэхүүнд нормативт нийцсэн тухай болон хамгаалах шинж чанаруудыг туршиж баталгаажуулсан тухай сертификат дагалдуулсан байна.</p>
Тоо ширхэг	500 хос
Баглаа боодол	Размер, рост болон бэлтгэн нийлүүлэгчийн нэрийг бичсэн байна.
Тендерийн материалын хамт 41 размерийн загвар ирүүлнэ.	